



# МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2020 он 10 дугаар  
сарын 09-ны өдөр

Дугаар Хэр/2393

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хийх мэдээллийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

2056223

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020.10.16-НЫ ӨДРИЙН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН  
ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙДЫН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР  
/КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Нэг.Дэлхийн улс орнуудын нөхцөл байдлын талаар

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын "хоёрдугаар давалгаа" гарч, хурдацтай тархаж байгааг анхааруулж буйтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар халдварын тархалтыг дотооддоо алдахгүй байх, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар коронавируст халдварын цар тахал дэлхийн 216 улс орон, нутаг дэвсгэрийг хамарч, нийт 35,659,007 хүн халдвар авч, 1,044,269 хүн нас барж, эдгэсэн хүний тоо 27,393,753 болж бүртгэгджээ.

Мөн дэлхийн 53 улс дотоодын хөдөлгөөнд, 70 улс олон нийтийн үйлчилгээний газар, цуглаан, сургуулийн үйл ажиллагаанд тус тус хязгаарлалт тогтоож, 109 улс хилээ хэсэгчлэн болон бүрэн хааж, хөл хорио тогтоох замаар халдвараас урьдчилан сэргийлэх, голомтыг устгах, тархалтыг хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс хамаарч халдварын тархалт улс орон бүрд харилцан адилгүй байгаа боловч хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт нь хамгийн үр дүнтэй байгааг ДЭМБ-аас онцолжээ.

Сүүлийн үед КОВИД-19 халдварын шинж тэмдэггүй хүн халдвар тараах тохиолдол нэмэгдэж байгаа бөгөөд уг вирус нь хүнээс хүнд халдварлахаас гадна хүнээс амьтанд, улмаар амьтнаас амьтанд халдварлаж байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.

ДЭМБ-ын судалгаагаар коронавирусын халдвар авч, эдгэсэн хүмүүсийн дунд эсрэг биет үүссэн байдал харьцангуй бага буюу 1-10 хувьтай байгаа бол бусад судалгаанд 14-15 хувьтай байна.

"КОВИД-19 халдвар цаашид ч тархах төлөвтэй, ирээдүйд голомтот халдвар дэгдсээр байх болно" гэж ДЭМБ-аас мэдээлээд байна.

## 2.Монгол Улс дахь нөхцөл байдлын талаар

2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс 10 дугаар сарын 8-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 26,950 хүнд тандалт судалгаа явуулж, давхардсан тоогоор 74,522 хүнд шинжилгээ хийснээс бусад улс орноос зөөвөрлөгдөн орж ирсэн 315 тохиолдлыг илрүүлэн оношилж, түүнээс 308 хүнийг эмчилж эдгээсэн бол 7 хүн /биеийн байдал хөнгөн 6, хүндэвтэр 1/ ХӨСҮТ-д эмчлэгдэж байна.

Батлагдсан тохиолдлын хувьд:

-ОХУ-200, Афганистан-55, бусад улс-60 (Казахстан-17, АНУ-9, Их Британи-7, Беларусь-5, Швед-5, Солонгос-4, Франц-3, Чехословак-2, Тайланд-2, Итали, Бельги, Швейцарь, Бангладеш, Польш, Танзани улсаас тус бүр 1) тохиолдол;

-үүнээс Алтанбулагийн боомтоор 106, тусгай үүргийн онгоцоор 191, ТИР машины жолооч нараас 18 тохиолдол тус тус зөөвөрлөгдсөн;

-хүйсийн хувьд: 215 (68,2%) нь эрэгтэй, 100 (31,8%) нь эмэгтэй;

-дундаж нас 28 (6-84 настай), үүнд: 15-аас доош насны хүүхэд 8, 55-аас дээш насны 21 хүн байна;

-эмчилгээний ор хоног 14-64, дундаж ор хоног 30 байна.

КОВИД-19 халдвар зөөвөрлөгдөн орж ирэх болон хүн амын дунд тархах эрсдэлийн үнэлгээг 2020 оны 1 дүгээр сараас хойш нийт 12 удаа хийснээс гадна хилийн Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтод коронавируст халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийн үнэлгээ, 21 аймаг болон гамшгаас хамгаалах улсын 8 албанд хариу арга хэмжээ авах чадавхийн үнэлгээг тус тус хийсэн бөгөөд "өндөр" эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

Эрсдэлийн үнэлгээний багийн дүгнэлтээс үзэхэд манай улсын хүн амын дунд халдвар тархаж, 1 хувь буюу 32,000 хүн халдварт өртвөл түүний 4,935 хүний биеийн байдал хүндрэх, 1,645 хүний биеийн байдал маш хүнд эрчимт эмчилгээнд орох, 1,481 хүн нас барах магадлалтай байна.

Гурав.Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар

3.1.Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар:

КОВИД-19 халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар 15 удаа, Улсын онцгой комиссын хурлаар 28 удаа, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 удаа, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурлаар 1 удаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар 3 удаа тус тус хэлэлцүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах онцгой бодлого хэрэгжүүлэхээр заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Шадар сайдын санаачилгаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "КОВИД-19 халдвараас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах стратеги төлөвлөгөө" боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөхүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Тус ажлын хэсгээс нийгэм, эдийн засгийн салбарыг сэргээх чиглэлээр санал боловсруулж байгаа бөгөөд тэдгээрийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн нарийвчилсан төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна.

Түүнчлэн КОВИД-19 халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон олон улсын байгууллага, бусад донор байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлоготой уялдуулах зорилгоор Монгол Улсын Шадар сайд, ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн хамтран удирдах "Эрүүл мэндийн салбарын хүмүүнлэгийн тусламжийн баг"-ийг ажиллуулж эхэллээ.

Ингэснээр олон улсын тусламж, хандивын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, манай улсын КОВИД-19 халдвараас хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн олон улсын түнш байгууллагуудын нөөц боломжийг нэгдмэл төлөвлөлттэйгөөр дайчлан хуваарилах, хамтын ажиллагааны уялдааг сайжруулах боломж бүрдэх юм.

Мөн КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ялангуяа халдварын тохиолдол хүн амын дунд бүртгэгдсэн болон тархсан үед хүний нөөцийн бэлэн байдлыг хангах зорилгоор халдварын голомтод талбарын тархвар судлаачдыг дайчлан ажиллуулахад мөрдөх журам, үйл ажиллагааны

төлөвлөгөө, нэмэлт хүний нөөцийг бэлтгэх богино хугацааны онлайн сургалтын хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Ингэснээр КОВИД-19 халдвар бүхий иргэдийг амжилттай эмчилж байгаа ХӨСҮТ-ийн эмч, сувилагчдын тэргүүн туршлага, мэдлэгт суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг сургагч багш болгох замаар эмнэлгийн ажилтнуудыг тогтмол сургалтад хамруулж, эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдолд халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ, асаргааны арга барилыг эзэмшсэн эмч, сувилагчийн нөөцийг хот, суурин газар болон аймгийн эмнэлгүүдэд бэлтгэх болно.

Цаашлаад КОВИД-19 халдвартай өвчтнийг эмчлэх монголын эмч, сувилагчдын туршлагыг ДЭМБ-ын Номхон далайн бүс орнуудын газраас зохион байгуулдаг КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх вебинар буюу онлайн сургалт, семинарын цуврал хөтөлбөрт албан ёсоор оруулахаар төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газраас дэлхий нийтэд коронавируст халдварын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгахаар шийдвэрлэсэн.

Энэ хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журмыг баталж, шаардагдах зардлыг шийдвэрлээд байна.

### 3.2. Гадаадаас иргэдийг татан авах ажиллагааны талаар:

Коронавируст халдварын цар тахлын улмаас хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр гадаадад гацсан монгол иргэдийг татан авах ажиллагааг шат дараатайгаар тасралтгүй зохион байгуулж байна.

2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн байдлаар дэлхийн 81 улс орноос 23750 иргэн /эрэгтэй-11055, эмэгтэй-12515/-ийг татан аваад байна.

Үүнээс 85 удаагийн тусгай үүргийн нислэгээр 17029, газраар 6541 /Алтанбулаг, Замын-Үүд авто замын боомтоор/ иргэнийг тус тус татан авчирлаа.

2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад хандан дэлхийн 48 улсаас 10654 иргэн эх орондоо буцах хүсэлт гаргасан байна. Үүнд:

- бага насны хүүхэдтэй-1801;
- эрүүл мэндийн шалтгаантай-463;
- өндөр настан-462;
- жирэмсэн-163;
- оюутан-1166;
- санхүүгийн боломжгүй болсон-486;
- бусад шалтгаантай-6113.

Энэ сарын эхний долоо хоногт гурван удаагийн захиалгат нислэгээр 580 иргэнээ татан авсан бөгөөд цаашид хуваарийн дагуу дараах захиалгат нислэгийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна:

- 10 дугаар сарын 8-нд Сөүл-Улаанбаатар;
- 10 дугаар сарын 10-нд Токио-Улаанбаатар;
- 10 дугаар сарын 12-нд Сөүл-Улаанбаатар;

-10 дугаар сарын 16-нд Сөүл-Улаанбаатар /транзит/;  
-10 дугаар сарын 17-нд Сөүл-Улаанбаатар;  
-10 дугаар сарын 18-нд Сөүл-Улаанбаатар;  
-10 дугаар сарын 19-нд Сөүл-Улаанбаатар;  
-10 дугаар сарын 20-нд Сөүл-Улаанбаатар;  
-10 дугаар сарын 23-нд Франкфурт-Улаанбаатар чиглэлд тус тус нислэг үйлдэх бол Сиатл-Улаанбаатар чиглэлийн нислэгийн хугацаа одоогоор тодорхойгүй байна.

Улсын онцгой комиссын шийдвэрээр хилийн чанадад санхүүгийн хүндрэлд орсон, орон байргүй, нутаг буцах зардалгүй болсон иргэддээ дэмжлэг үзүүлэх зорилгоор 300 сая төгрөгийг "Хилийн чанадад байгаа иргэдэд туслах сан"-д шилжүүлсэн.

Түүнчлэн НҮБ-ын Шуурхай хариу арга хэмжээний сангаас 1,0 сая ам.долларын санхүүжилт босгох зорилгоор НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай хамтран ажиллаж байна.

Эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх үүрэг бүхий тусгай ажлын хэсгийг байгуулсан бөгөөд үйл ажиллагаанд нь холбогдох хууль, хяналтын байгууллагууд хяналт тавин ажиллаж байна.

Захиалгат нислэгт хамрагдах иргэдийн нэрийг ил тод, нээлттэй болгох, иргэдийг чирэгдэлгүйгээр жагсаалтад оруулах талаар Улсын онцгой комиссоос үүрэг өгснөөр 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрууд захиалгат нислэгт хамрагдах иргэдийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлаж байна.

Сүүлийн саруудад тусгай үүргийн нислэгийн чиглэл, давтамжийг тогтмол нэмэгдүүлж, гадаадаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах ажиллагааг эрчимжүүлж байгаатай холбогдуулан КОВИД-19 халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл "өндөр" хэвээр байгааг бүх шатанд анхаарч ажиллаж байна.

### 3.3.Тусгаарлах байрны нөөц боломжийн талаар:

Гадаадаас иргэдээ татан авах ажиллагаа нь тусгаарлах байрны хүрэлцээ, эрүүл мэндийн байгууллага, түүний дотор ХӨСҮТ-ийн вируслогийн лабораторийн хүчин чадал, оношлуурын нөөц, эрүүл мэндийн ажилтнуудын хүрэлцээ зэргээс ихээхэн хамаарч байна.

2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 23:00 цагийн байдлаар улсын хэмжээнд нийт 3679 иргэн 76 тусгаарлан ажиглах байранд байна. Үүнээс Улаанбаатар хотод Монгол Улсын иргэн-2150, гадаадын иргэн-794; орон нутагт Монгол Улсын иргэн-463, гадаадын иргэн-272 байна.

Тусгаарлагдсан иргэдэд 2800-3200 ккал илчлэгтэй хоол хүнсээр өдөрт гурван удаа үйлчилж байгаа бөгөөд хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл, шаардлага, хүнсний аюулгүй байдалд эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллаж байна.

Тусгаарлах байранд эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын болон аж ахуйн нэгжийн нийт 410 ажилтан, алба хаагч томилогдон, иргэдийн эрүүл мэндийг хянах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллаж байна.

Мөн тусгаарлах байрны өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухайн байгууллага, харин эцсийн халдваргүйжүүлэлтийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв хариуцан гүйцэтгэж байна.

Тусгаарлах байрны зориулалтаар ашиглах зочид буудлыг сонгохдоо нэг дор 40-өөс дээш тооны иргэдийг хүлээн авах, нэг өрөөнд нэг хүнийг тусгаарлах, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөө (гар нүүр угаах, усанд орох, бие засах)-тэй байх, хоол үйлдвэрлэл (зориулалтын гал тогоо, мэргэжлийн ажилтантай байх)-ийн шаардлага хангасан байх, цагдаагийн хамгаалалт гаргахад тохиромжтой байх зэрэг нөхцөл байдлыг харгалзан аж ахуйн нэгжтэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 266 зочид буудал, амралтын газар үйл ажиллагаа явуулж байгаагаас дээрх шаардлагыг хангаж, харилцан зөвшилцсөн нийт 28 зочид буудал, 1 амралтын газар, 1 сувилалд тус тус иргэдийг тусгаарлан ажиглаж байна.

Харин үлдсэн 153 зочид буудал, 43 амралтын газрын 25 хувь нь гал тогоогүй, нийтийн ариун цэврийн өрөөтэй, 27 хувь нь усан хангамжийн инженерийн нэгдсэн шугамд холбогдоогүй тул гар, нүүр угаах, усанд орох, бие засах зэрэг эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй, 48 хувь нь орны тоо хэт цөөн зэргээс шалтгаалан тусгаарлах байрны зориулалтаар ашиглах боломжгүй байна.

ХӨСҮТ нь 250 халдвартай өвчтөн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд тус төвийн 35 их эмч, 60 сувилагч, 14 ариутгагч ажилтан "Халдвар хамгааллын дүрэм"-ийн дагуу 28 хоног (14 хоног өвчтөнтэй ажиллаж, 14 хоног эмнэлэг дээрээ тусгаарлагддаг)-оор ээлжлэн голомтод ажиллаж байна.

Хүн амын дунд КОВИД-19 халдвар тархсан үед Хан-Уул дүүргийн эх, нялхсын 300 ортой эмнэлгийг 1000 ортой болгон өргөтгөн зохион байгуулж ашиглахаар төлөвлөж байна.

Мөн тус дүүрэгт шинээр баригдаж байгаа Түлэнхийн төвийг ашиглалтад оруулснаар 200, Геронтологийн төвийн Ахмадын эмнэлэгт 60, нийт 260 ор гарах боломжтой юм.

2020 оны 10 дугаар сараас эхлэн улирлын томуу өвчний дэгдэлт эхэлж, эрсдэлт нөхцөл байдлыг улам хүндрүүлж, КОВИД-19 халдварын тархалттай хавсарч тархах магадлал маш өндөр байгааг эрүүл мэндийн мэргэжилтнүүд онцгойлон анхааруулж байна.

Иймд томуугийн вакцины захиалгыг шуурхай хийж, нөөцийг үндэсний хэмжээнд бүрэн хангах хүрээнд ХӨСҮТ болон аймаг, сумдын эмнэлгүүдийн нөөцийг сайжруулахад анхаарч ажиллаж байна.

### 3.4. Санхүүжилтийн талаар:

2020 оны төсвийн тодотголоор гамшгийн голомтод ажиллаж байгаа албан хаагчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангахад:

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт 1.2 тэрбум төгрөг;

-Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт 2.8 тэрбум төгрөг;

Гаалийн ерөнхий газарт 2.2 тэрбум төгрөг, нийт 6.2 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн.

Эрүүл мэндийн салбарт коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зориулалтаар:

-хувийн хамгаалах хэрэгсэл, эм-55.8 тэрбум төгрөг;

-эрүүл мэндийн дэмжих төв-8.4 тэрбум төгрөг;

-лабораторийн шинжилгээ-6.8 тэрбум төгрөг, нийт 71.0 тэрбум төгрөг.

Түүнчлэн:

-улирлын томуугийн болон коронавирусийн вакцин хийхэд 22.3 тэрбум төгрөг;

- Цэргийн төв эмнэлэгт 8 тэрбум төгрөг;
- Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт 0.2 тэрбум төгрөг;
- Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Сэргээн засах төвд 1.1 тэрбум төгрөг;
- ХӨСҮТ, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилтнуудын илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, ар гэрт олгох дэмжлэгт 10.1 тэрбум төгрөг;
- сувилагч мэргэжлээр суралцагчдын сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд 5.9 тэрбум төгрөг, нийт 118.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээ.

### 3.5.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн хандив, тусламжийн талаар:

2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжиж, 290 аж ахуйн нэгж, байгууллага, 257 иргэнээс нийт 3.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө; 121 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс нийт 4.3 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа материалыг Улсын онцгой комисст хандивласан.

Үүнээс 6.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материалыг Улсын онцгой комиссын Шуурхай штаб, холбогдох төрийн байгууллагууд, нийслэлийн авто замын шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэг, тусгаарлах байрны хэрэгцээ болон шаардлагатай тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд зарцуулаад байна.

### 3.6.Мэдээ, мэдээлэл, сурталчилгааны талаар:

Коронавируст халдварын цар тахлын халдвараас сэргийлж, маск зүүх, гар ариутгах, хүн хоорондын зай барихыг олон нийтэд сурталчлан анхааруулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Энэ хүрээнд зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг мэдээ түгээх олон суваг, хэлбэрээр хүргэж байна. Тухайлбал, эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр 355 төрлийн цуврал инфографик, 215 төрлийн мэргэжлийн эмчийн зөвлөмж, 20 шторкийг бэлтгэн Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулан давхардсан тоогоор 19,565,000 иргэнд мэдээлэл хүргэжээ. Түүнчлэн тус яамны цахим хуудсанд "COVID-19" цэс нээж, коронавирустай холбоотой 71 сурталчилгааны материал, зөвлөмжийг байршуулжээ.

НҮБ-ын Хүүхдийн сангаар 21 төрлийн сурталчилгааны материалыг 605,000 ширхэгийг хэвлүүлж, эрүүл мэнд, боловсролын болон холбогдох бусад байгууллагаар тараан сурталчилж байна.

Коронавируст халдварын талаар иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор өдөр бүрийн 11:00 цагт хэвлэлийн бага хурал хийж, нийт 303 удаа шууд мэдээлэл хүргэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсаар бичлэгийг дамжуулахад 19,899,800 хүн хандалт хийж, 92,850 хүн мэдээллийг хуваалцжээ.

Цаашид коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Амны хаалтаа зүүцгээе" 2 дугаар аяныг өрнүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

КОВИД-19 халдварын цар тахлын аюул одоо ч хэвээр байгаа тул сонор сэрэмжээ сулруулалгүй, дор бүрдээ амны хаалт зүүж, гараа ариутгах, хүн хооронд зай барих зэрэг нийгмийн эрүүл мэндийн шалгарсан аргаа байнга мөрдөхөд иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн хүчин чармайлт, оролцоо, хариуцлага нэн чухал хэвээр байна.

### 3.7.Эдийн засгийг эрчимжүүлэх, төсвийн бодлогын чиглэлээр:

КОВИД-19 халдварын цар тахлын улмаас улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээл дахь гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, эрэлт буураад байсан боловч Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, дунд

хугацаанд эрчимжүүлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж ирлээ.

Энэ хүрээнд хил дээрх ариутгал, халдваргүйжүүлэлтийг нэмэгдүүлж, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ нүүрс, газрын тос болон ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх ажлыг тууштай явуулж байна.

Ингэснээр энэ оны 2 дугаар сард өдөрт дунджаар 55 нүүр ачсан машин гарч байсан бол өнөөдрийн байдлаар өдөрт дунджаар 1012 нүүрс ачсан машин гарч, нүүрсний экспорт тогтмол нэмэгдэж байна.

2021 онд газрын тосны үйлдвэр, экспортын төмөр зам, төв цэвэрлэх байгууламж зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд үргэлжлэн хэрэгжихийн зэрэгцээ гааль, боомтын шинэчлэл, Оюутолгой төслийн далд уурхайн барилга, угсралтын ажил үргэлжлэн явагдана. Үүний үр дүнд эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжиж, өсөлт нэмэгдэхээр байна.

Нөгөө талаар Засгийн газраас иргэд, бизнес эрхлэгчдийнхээ амьжиргаа, орлогыг дэмжих, ажлын байрыг хадгалж хамгаалах, эдийн засгийг сэргээх, идэвхжүүлэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хувилбаруудыг ирэх жилийн төсвийн бодлогын хүрээнд боловсруулж байна.

Тухайлбал, КОВИД-19 халдварын цар тахлын үед үйл ажиллагаа нь доголдсон боловч ажлын байраа хадгалж байгаа ажил олгогч болон даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх болон хөнгөлөх арга хэмжээг 2020 онд хоёр үе шаттай авч хэрэгжүүлж байна. Үүнд:

-нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд бүрэн чөлөөлсөн;

-харин 2020 оны 10-12 дугаар сард нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч 5 хувь, даатгуулагч 5 хувь байхаар тооцож, хөнгөлөлт байдлаар хэсэгчлэн үргэлжлүүлэхээр болсон.

Нөгөө талаар 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дээрх чөлөөлөлт болон хөнгөлөлтөд хамрагдсан ажил олгогч аж ахуйн нэгж, даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэлийг 22 хувиар төлөх учиртай.

Гэтэл КОВИД-19 халдварын цар тахлын эдийн засгийн сөрөг үр дагавар цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа тул Засгийн газраас ажилгүйдэл, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл нийт дүнгээр нь 3-5 пунктээр бууруулах замаар нийгмийн даатгалын шимтгэлийн нийт хэмжээг 17 хувьд хүргэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хувьд 2021 оны эхний хагас жилийг дуустал нэмэгдсэн хэмжээгээр буюу сар бүр 100,000 төгрөгийг үргэлжлүүлэн олгохоор тооцож, нийт 1,2 сая хүүхдэд олгох 864 тэрбум төгрөгийг 2021 оны төсвийн төсөлд тусгалаа.

Мөн нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 100,000 төгрөгөөр нэмэгдүүлж 288,000 төгрөг олгож байна.

Энэхүү арга хэмжээг 2021 оны эхний хагас жил нэмэгдүүлсэн дүнгээр үргэлжлүүлэн олгохоор тооцож төсөвт тусгасан. Ингэснээр халамжийн сангаас тэтгэвэр авдаг 72 мянга орчим ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой иргэн, өнчин хүүхэд, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сар бүр 288,000 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн авах боломж бүрдэх юм.